


2012

# Хэвлэл мэдээллийн мониторинг 2-р шат

“2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧ  
ЭМЭГТЭЙЧҮҮДИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД  
ХИЙГДСЭН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН МОНИТОРИНГИЙН  
ХОЁР ДАХ ШАТНЫ ДҮН

ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ



## Гарчиг

1. Товчилсон нэрний тайлбар .....	3
2. Нэр томъёоны тайлбар .....	3
3. Тайлангийн хураангуй .....	4
4. Мониторингийн үндэслэл.....	5
5. Мониторингийн зорилго, зорилт.....	5
6. Мониторингийн арга зүй.....	6
6.1 Мониторингийн хамрах хүрээ.....	6
6.2 Мониторингийн аргачлал.....	6
7. Мониторингийн үр дүн.....	8
7.1.1 Сонины үр дүн.....	8
7.1.2 Цахим хуудасны үр дүн.....	10
7.1.3 Google.mn үр дүн.....	12
7.1.4 Телевизийн үр дүн .....	14
8. Ерөнхий дүгнэлт.....	15
9. Хавсарлт .....	16

## **ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛБАР**

<b>ТББ</b>	Төрийн бус байгууллага
<b>МҮОНРТ</b>	Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
<b>ХМХ</b>	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
<b>УИХ</b>	Улсын Их Хурал
<b>ТВ</b>	Телевиз
<b>ОУ</b>	Олон улс

## **НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР**

<b>Өргөн хэрэглээний цахим хуудас</b>	Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар хамгийн олон хэрэглэгчидтэй цахим хуудсууд
<b>Мэдээллийн хэрэгсэл</b>	Олон нийтэд албан ёсны зөвшөөрөлтэйгөөр мэдээлэл түгээж байгаа хэрэгслүүд бөгөөд үүнд: Телевиз, радио, сонин, интернетийг ойлгоно
<b>Эмэгтэй улс төрчид</b>	2008 оны УИХ-н сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүд болон 2012 оны УИХ-н сонгуульд нэр дэвших магадлал бүхий хүмүүс хамрагдана.

## ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Глоб Интернэшнл ТББ АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд эмэгтэй улс төрчдийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэрхэн мэдээлсэн байдалд хийсэн 2 дахь шатны мониторингийг 2012 оны 1-р сарын 16-22-ны өдөр, 2, 3-р сарын 1-7-ны өдрийн хугацаанд хийж гүйцэтгэв.

Хэвлэл мэдээллийн мониторингт өдөр тутмын “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, долоо хоног тутмын “Хүмүүс”, “Сэрүүлэг” сонин, (цаашид сонин гэнэ) МҮОНРТ, 25-р суваг ТВ (1-р суваг), Боловсрол суваг ТВ, (цаашид телевиз гэнэ) [www.news.mn](http://www.news.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.factnews.mn](http://www.factnews.mn), [www.caak.mn](http://www.caak.mn), [www.medee.mn](http://www.medee.mn), [www.amjilt.com](http://www.amjilt.com), [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) (цаашид цахим хуудас гэнэ) болон [www.google.mn](http://www.google.mn) хайлтын системийг хамруулсан болно.

Ажиглагчид тусгайлан боловсруулсан түлхүүр асуулт бүхий тэмдэглэлт хүснэгтийн дагуу тоон болон чанарын мэдээлэл цуглуулж, Excel программд оруулж кодлон, SPSS 16.0 программаар боловсруулав. Мөн Google хайлтын системээс “*эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигч*” гэсэн хоёр түлхүүр үг ашиглан хайлт хийж, сонгосон хугацаанд гарсан мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ.

Мониторингийн хугацаанд 5 сонин, 3 телевиз, 8 цахим хуудас, google.mn хайлтын систем бүхий хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй улс төрчтэй холбоотой 420 мэдээлэл гарсан байна. Үүнээс 15 хувь нь сонинд нийтлэгдсэн, 66 хувь нь интернэтэд (8 цахим хуудас, google.mn) тавигдсан, 19 хувь нь телевизээр цацагдсан байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд нийт 52 эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл гарсан. Үүнээс Д.Оюунхоролтой холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 13,5 хувийг эзэлж байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байлаа. Харин одоогийн УИХ-ын эмэгтэй гишүүд болох С.Оюун, Д.Арвин, Д.Оюунхорол нартай холбоотой мэдээлэл нийт мэдээллийн 28,8 хувийг эзэлж байна. ХМХ-ээр эмэгтэй улс төрчдийн тухай сонинууд 1-4-р нүүрэндээ, цахим хуудсууд “Улс төр” буландаа, телевизүүд мэдээний цагаар хамгийн их мэдээлсэн байна. Нийт мэдээллийн 77 хувь нь төвийг сахисан байдлаар, 16 хувь нь эерэг, 6 хувь сөрөг байдалтай байна. Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийг шууд болон шууд бус гэж ангилсан. Нэр нь гарч байгаа эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийг тухайн хүн өөрөө өгсөн бол шууд, тухайн хүний тухай өөр улс төрч, иргэд, эсвэл сэтгүүлч хэлсэн, бичсэн мэдээллийг шууд бус хэмээн үзсэн. Ингэж үзэхэд эмэгтэй улс төрчидтэй хийсэн ярилцлага, сурвалжлага маш бага харин хэн нэгний ярианд, сэтгүүлчийн нийтлэлд дурьдагдаад өнгөрөх байдлаар ихэнх мэдээлэл нь гарсан байна. Энэ нь эмэгтэй улс төрчдийн үзэл бодол, дуу хоолой олон нийтэд хүрч чадахгүй, харин хоёрдогч хүний байр сууринаас тэдний талаарх ойлголт бий болж бодит бус мэдээллийг иргэд ихэвчлэн авч байна.

1-р шатны тайлантай харьцуулахад илүү олон эмэгтэй улс төрчдийн тухай гарсан ч мэдээлэл гарсан талбайн хэмжээ, үргэлжлэх хугацаа, шууд эсвэл шууд бус эх сурвалжтай зэргээс харахад мэдээллийн давтамж, эзлэх хэмжээ багасжээ. Харин тухайн эмэгтэй улс төрч болон төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх үнэлэмж эерэг өнгө аястай болсон. Тэдний талаарх ойлголт, тодорхойлолт, төсөөллийн утга агуулга дэмжсэн, магтсан байдлаар бичигдэж, эерэг хандлагатай болсон дэвшилттэй үр дүн харагдаж байна.

## МОНИТОРИНГИЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс ардчиллын замыг сонгоод 21 жилийн нүүр үзээд байна. Энэ хугацаанд иргэд УИХ-ын гишүүдийг сонгох болон Ерөнхийлөгчийг сонгох сонгуулиудад оролцож, шийдвэр гаргах түвшиний хүмүүсийг сонгож ирсэн билээ. Өнөөдөр эргэн харахад өнгөрөгч таван удаагийн УИХ-ын сонгуулиар сонгогдож байсан эмэгтэй улс төрчдийн тоо аль ч сонгуулийн үеэр эрэгтэй улс төрчдийн тооноос илт цөөн байна.

Дэлхийн олон орон жендэрийн тэгш эрх, тэгш байдлын хэмжээгээр тухайн орон дах ардчилал хэр бодитой байгааг үнэлдэг. Тэгвэл дээрх жишээгээр манай оронд шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал учир дутагдалтай байгаа нь сөрөг нөлөө үзүүлж, ардчиллын үнэт зүйлс алдагдахад хүргэж байна. Энэ тэнцвэргүй байдалд олон хүчин зүйл нөлөөлөх нь дамжиггүй. Тэдний нэг нь өргөн цар хүрээтэйгээр сурталчилгаа, танин мэдэхүйн болон нөлөөллийн үүрэг гүйцэтгэж байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа мэдээлэл юм.

Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгслээр эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээлэлд мониторинг хийх шаардлагатай байна.

Глоб Интернэшнл ТББ Их Британий Элчин Сайдын яамны санхүүжилтээр, АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд 2008 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн эмэгтэйчүүд, эмэгтэй улс төрчид, нэр дэвшигчдийн талаар сонин хэвлэл болон өргөн хэрэглээний цахим хуудас, телевизүүдээр цацагдсан мэдээлэл, сурталчилгаанд мониторинг хийлээ.

### Мониторингийн зорилго, зорилт

2015 онд шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрчид 30 хувьд хүрсэн байна гэсэн Мянганы хөгжлийн зорилтод чиглэн өнгөрөгч 2008 оноос хойш эмэгтэй улс төрчдийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээ мэдээллийн ерөнхий дүр төрх, төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй хүний талаар ямар санал бодол, ойлголт, төсөөлөл байгааг илрүүлэх зорилготой.

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээллийн эзлэх хэмжээ, ач холбогдол өгсөн байдал (эрэгтэй нэр дэвшигчтэй харьцуулсан байдлаар, мэдээллийн хэрэгслийн аль хэсэгт гарснаар нь үнэлэх)
2. Тухайн нэр дэвшигчийн болон төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх үнэлэмж (1-ээс 5-н баллаар үнэлэн гаргах)
3. Эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээлэл шууд болон шууд бус байдлаар бичигдсэн.
4. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийг ямар байгаасай, мөн яагаад эмэгтэй хүн тохирохгүй гэж үзэж байгааг тодруулах. (Мэдлэг боловсрол, нас, гадаад төрх, ажлын туршлага, зан чанар гэх мэт)

## МОНИТОРИНГИЙН АРГА

### Мониторингийн хамрах хүрээ

Уншигч захиалагчдын тоогоороо хамгийн их

- “Өдрийн сонин”
- “Өнөөдөр”
- ”Зууны мэдээ”
- “Хүмүүс”
- “Сэрүүлэг” гэсэн 5 сонин.

Хэвлэлийн хүрээлэнгийн 2011 онд хийсэн судалгаагаар хамгийн олон үзэгчидтэй

- МҮОНРТ
- 25-р суваг ТВ I-р суваг
- Боловсрол суваг ТВ гэсэн 3 телевиз.

Хэвлэлийн хүрээлэнгийн 2008-2011 онд хийсэн судалгаагаар хамгийн олон хэрэглэгчидтэй

- [www.news.mn](http://www.news.mn)
- [www.olloo.mn](http://www.olloo.mn)
- [www.factnews.mn](http://www.factnews.mn)
- [www.caak.mn](http://www.caak.mn)
- [www.medee.mn](http://www.medee.mn)
- [www.amjilt.com](http://www.amjilt.com)
- [www.gogo.mn](http://www.gogo.mn)
- [www.shuud.mn](http://www.shuud.mn) гэсэн 8 цахим хуудас, [www.google.mn](http://www.google.mn) хайлтын систем хамрагдсан.

Хоёрдугаар ээлжийн мониторингийн хугацаа:

- 2012 оны 1-р сарын 16-22-ны өдөр
- 2012 оны 2-р сарын 1-7-ны өдөр
- 2012 оны 3-р сарын 1-7-ны өдрийг дуустал хэмээн үзсэн.

### Мониторингийн аргачилал

Урьдаас бэлтгэсэн түлхүүр асуулт бүхий тэмдэглэлт хүснэгтийн дагуу мэдээллийг бүрдүүлж, Excel программд оруулж кодлон, SPSS 16.0 программаар боловсруулав.

Мөн Google хайлтын системээс “эмэгтэй улс төрч, эмэгтэй нэр дэвшигч” гэсэн түлхүүр үг ашиглан дээрх заасан хугацаанд нийтлэгдсэн мэдээллүүдийг шүүн, дүн шинжилгээ хийлээ. Google хайлтын системээс илэрсэн мэдээлэл дотор сонгосон цахим хуудсуудад байх мэдээлэл орсон бол давхцуулахгүйн тулд хасаж тооцсон болно.

Мониторингийн маягтыг бөглөхдөө сонины мэдээллийн хэмжээг см<sup>2</sup>-р, телевизийг секундээр хэмжсэн. Үүнд:

- Мэдээлэл нэг см<sup>2</sup>-н дотор байвал бүхэл 1см<sup>2</sup> гэж тооцсон.
- Нэр дэвшигчийн зураг байвал текстээс тусад нь тооцсон.
- Нэр дэвшигч өөр нэр дэвшигчийн хамт, эсвэл намынхантайгаа хамт байвал зургийг том жижиг гэж үзэлгүй 1 см<sup>2</sup> гэж тооцсон.
- Харин нэр дэвшигч ганцаараа, эсвэл гэр бүлийнхэн, урлаг соёлын одод зэрэг улс төрөөс ангид хүмүүстэй хамт авахуулсан бол зургийн хэмжээг байгаагаар нь тооцов.
- Мэдээлэл 1-3 секунд дотор байвал шууд 3 секунд гэж тооцсон.
- 4 болон түүнээс дээш секунд бол үргэлжилсэн хугацааг байгаагаар нь бичсэн.

Нэр дэвшигчийн өнгө аясыг 1-5 гэсэн кодоор нарийвчлан дүгнэж, 1, 2-р үнэлэмжийг эерэг, 4, 5-р үнэлэмжийг сөрөг өнгө аястай гэж дүгнэсэн.

1. Нэр дэвшигчийг хэт магтсан.
2. Сайшааж, боломжийн хэмээн үзсэн.
3. Төвийг сахисан.
4. Муучилж, дарсан.
5. Хэт муулж доромжилсон.

Шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй. 1-5 гэсэн кодоор нарийвчлан дүгнэж, 1, 2-р үнэлэмжийг эерэг, 4, 5-р үнэлэмжийг сөрөг өнгө аястай гэж дүгнэсэн.

1. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч зайлшгүй хэрэгтэй.
2. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй.
3. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч байж ч болно байхгүй байж ч болно. Төдийлөн чухал биш.
4. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч бараг хэрэггүй.
5. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч огт хэрэггүй.

## МОНИТОРИНГИЙН ҮР ДҮН

### СОНИНЫ ҮР ДҮН

Сонин дээр гарсан улс төрчидтэй холбоотой нийт мэдээллээс зөвхөн эрэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл 71 хувь, зөвхөн эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл 14 хувь, харин хүйсээр ялгаварлаагүй улс төрчдийн талаарх ерөнхий мэдээлэл 15 хувийг эзэлж байна. **(Зураг 5.)**

Эмэгтэй улс төрчидтэй холбоотой нийт мэдээллийн 28 хувь нь “Зууны мэдээ” сонин дээр, 27 хувь нь “Өнөөдөр” сонин дээр, 22 хувь нь “Өдрийн сонин” дээр, 12 хувь нь “Хүмүүс” сонин дээр, 11 хувь нь “Сэрүүлэг” сонин дээр тус тус гарсан байна. **(Зураг 6.)** Өмнөх тайлантай харьцуулахад өдөр тутмын сонин дээрх мэдээлэл 113 хувиар өсөж, өдөр тутмын бус сонин дээрх мэдээлэл 56 хувиар буурсан байв.

Нэр дурьдагдсан, дурьдагдаагүй улс төрчдийн талаар нийт 158081 см<sup>2</sup> талбайд мэдээлэл гарсан, нэг сонины нүүрийг дунджаар 1565 см<sup>2</sup> гэж үзвэл сонины 101 нүүр материал болж байна. Үүний 80 хувийг зөвхөн эрэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл, 8 хувийг зөвхөн эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл, 11 хувийг хүйс ялгаагүй ерөнхийд нь улс төрчдийн талаар гарсан мэдээлэл эзэлж байна. Сонин тус бүрээр нь үзвэл “Өнөөдөр” сонин 4 дахин, “Өдрийн сонин” 8 дахин, “Зууны мэдээ” сонин 8 дахин, “Хүмүүс” сонин 11 дахин, “Сэрүүлэг” сонин 10 дахин бага талбайд эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл нийтэлжээ. **(Зураг 1.)**

**Зураг 1. Мэдээллийн талбайн хэмжээг сонин тус бүрээр харвал (хувиар)**



Өмнөх мониторингоор УИХ-ын гишүүн С.Оюунтай холбоотой 7 мэдээлэл гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт байсан. Харин энэ удаа С.Одонтуяа, П.Батчимэг нартай холбоотой мэдээлэл тус бүр 5 удаа гарсан нь хамгийн өндөр үзүүлэлт болж байна. Мониторингийн хугацаанд нийт 29 эмэгтэй улс төрчдийн нэрийг дурьдсан 64 мэдээлэл гарсан. Мэдээлэл гарсан давтамжийг нь харахад 3-5 удаа гарсан 10 хүн, 1-2 удаа гарсан 19 хүн байна. **(Зураг 2.)**

**Зураг 2 Сонин дээр хамгийн олон удаа мэдээлэл нь гарсан эхний 10 хүн**



Хамгийн олон удаа мэдээлэл нь гарсан гэх С.Одонтуяа, П.Батчимэг нартай холбоотой мэдээллийн нийт талбайн хэмжээ 817 см<sup>2</sup> буюу ойролцоогоор сонины тал нүүр материал болж, хамгийн их талбайд мэдээлэл нь гарсан М.Ичинноровоос (4312 см<sup>2</sup>) 5 дахин бага талбай оногджээ. Мэдээллийн давтамж, мэдээний эзлэх хэмжээ зэргийг харахад эмэгтэй улс төрчдийн тухай нэр дурьдаад өнгөрөх байдлаар мэдээлж байна. (Зураг 3.)

**Зураг 3 Сонин дээр хамгийн их талбайд мэдээлэл нь гарсан эхний 10 хүн**



Одоогийн эмэгтэй УИХ-ын гишүүдээс С.Оюун, Д.Оюунхоролтой холбоотой тус бүр нэг нэг мэдээлэл гарч харин Д.Арвинтай холбоотой нэг ч мэдээлэл байсангүй. Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл сонины 1-4-р нүүрэнд гарч байсан (Зураг 7.) бөгөөд төвийг сахисан байдлаар ихэвчлэн бичигдсэн байлаа. “Өдрийн сонин”, “Зууны мэдээ” сонинууд дээр гарсан бүх мэдээлэл төвийг сахисан, үлдсэн гурван сонины хувьд 91 хувь нь төвийг сахисан, 6 хувь нь эерэг байдлаар, 3 хувь нь сөрөг хандлагатай байв. (Зураг 8.) Нийт мэдээллийн 83 хувь нь шууд бусаар, 17 хувь нь шууд байдлаар бичигджээ. (Зураг 9.)

## ЦАХИМ ХУУДАСНЫ ҮР ДҮН

Цахим хуудаснуудын тухайд бидний сонгосон зарим өдрийн мэдээлэл архивлагдан хадгалагдаагүй байсан. Мөн сонгосон хугацааны зарим нэг өдөр, булангуудын мэдээлэл байхгүй байсан тул тухайн хугацаанд аль нэг буланд доод тал нь нэг мэдээлэл байгаа тохиолдолд хамрагдсан гэж үзэн шар дэвсгэрээр тодруулав.

Мэдээлэл гарсан байдлаар жагсаавал [www.news.mn](http://www.news.mn) 47 хувиар хамгийн их, дараагаар нь [www.medee.mn](http://www.medee.mn) 16,7 хувь, [www.olloo.mn](http://www.olloo.mn) 15,3 хувь, [www.shuud.mn](http://www.shuud.mn) 12,4 хувь, [www.gogo.mn](http://www.gogo.mn) 7,7 хувиар жагсаж байна. Харин [www.caak.mn](http://www.caak.mn) цахим хуудаснаас нэг ч мэдээлэл илрээгүй бөгөөд [factnews.mn](http://www.factnews.mn) -ээс 1-р сард 1, [amjilt.com](http://www.amjilt.com)-оос 3-р сард 1 мэдээлэл тус тус илэрсэн нь хамгийн бага мэдээлэл гарсан цахим хуудсууд байлаа. (Хүснэгт 1.)

### Хүснэгт 1. Цахим хуудсууд дах мэдээллийн тоо, хугацаа

Цахим сайтууд	Хугацаа 2012 он			Нийт	Хувь
	1-р сарын 16-22-нд	2-р сарын 1-7-нд	3-р сарын 1-7-нд		
<a href="http://www.news.mn">www.news.mn</a>	41	25	32	98	47%
<a href="http://www.medee.mn">www.medee.mn</a>	10	7	18	35	16,7%
<a href="http://www.olloo.mn">www.olloo.mn</a>	16	5	11	32	15,3%
<a href="http://www.shuud.mn">www.shuud.mn</a>	6	6	14	26	12,4%
<a href="http://www.gogo.mn">www.gogo.mn</a>	9	6	1	16	7,7%
<a href="http://www.factnews.mn">www.factnews.mn</a>	1	0	0	1	0,5%
<a href="http://www.amjilt.com">www.amjilt.com</a>	0		1	1	0,5%
<a href="http://www.caak.mn">www.caak.mn</a>	0	0	0	0	0%
<b>Нийт</b>	<b>83</b>	<b>49</b>	<b>77</b>	<b>209</b>	<b>100%</b>

Өмнөх тайлантай харьцуулахад заасан хугацаанд багтах мэдээллийн олдоц сайн байсан. Мэдээлэл гарсан байдлаар [news.mn](http://www.news.mn) дахин тэргүүлж, [medee.mn](http://www.medee.mn) цахим хуудас [olloo.mn](http://www.olloo.mn) сайтын өмнө орлоо. (Өмнөх мониторингийн 1-р долоо хоногийн [medee.mn](http://www.medee.mn) цахим хуудсны мэдээлэл байхгүй байсан.)

Цахим хуудас тус бүр дээр гарсан мэдээллүүдийг сараар нь харвал [gogo.mn](http://www.gogo.mn), [news.mn](http://www.news.mn), [olloo.mn](http://www.olloo.mn) 1-р сард, [medee.mn](http://www.medee.mn), [shuud.mn](http://www.shuud.mn) 3-р сард эмэгтэй улс төрчдийн талаар хамгийн их мэдээлэл гаргажээ. (Зураг 10.)

Сонгогдсон цахим хуудсуудад нийт 22 эмэгтэй улс төрчдийн талаарх мэдээлэл гарсан. Өмнөх тайлан дээр 27 эмэгтэй улс төрчөөс С.Оюун, Т.Ганди, Д.Арвин нар мэдээллийн тоогоор тэргүүлж, нийт мэдээллийн 54 хувийг эзэлж байсан бол энэ удаа Д.Оюунхорол, Д.Арвин, Т.Ганди С.Оюун нар тэргүүлж, нийт мэдээллийн 52 хувийг эзэлж байна. Харин нэр заагаагүй эмэгтэй улс төрчдийн талаарх ерөнхий мэдээллийн эзлэх хэмжээ 6 хувиас 14 хувь болсон, өмнө нь 10 хүний фото зураг гарч байсан бол энэ удаа 18 болж өссөн байна. (Зураг 11, 12.) Мөн хамгийн олон удаа мэдээлэл нь гарсан дээрх 4-н хүнээс гадна Ж.Цолмон, Ц.Оюунгэрэл гэсэн 6-н хүний мэдээлэл сар бүр гарсан байлаа. Өмнө нь гарч байсан М.Чимгээ, Х.Энхтуяа, Р.Бурмаа, О.Ариунсан, Л.Эрдэнэчимэг, И.Нарантуяа, О.Сэлэнгэ нарын мэдээлэл энэ удаа гарсангүй харин Д.Мөнхөө, Б.Болормаа, З.Нарантуяа нартай холбогдох мэдээлэл нэмэгджээ.

Мэдээлэл илэрсэн долоон цахим хуудаснаас тав нь тодорхой хэмжээгээр шууд мэдээлэл гаргасан ч өмнөх тайлантай харьцуулахад шууд байдлаар бичигдсэн мэдээллийн эзлэх хувь 26 хувиар буурч, шууд бусаар бичигдсэн мэдээллийн эзлэх хувь 9,7 хувиар өссөн байна. (Зураг 13.)

[amjilt.com](http://www.amjilt.com) –ын 3-р сар, [factnews.mn](http://www.factnews.mn)-ын 1-р сар, [gogo.mn](http://www.gogo.mn) –ын 1, 2-р сар, [medee.mn](http://www.medee.mn) –ын 2, 3-р сар, [olloo.mn](http://www.olloo.mn) –ын 1, 3-р сар, [shuud.mn](http://www.shuud.mn) –ыг 2, 3-р сарын мэдээллүүд бүгд шууд бус байдлаар

бичигдсэн. Харин [news.mn](http://news.mn) –ын 1-ээс 3-р сарын бүх мэдээлэл шууд болон шууд бус байдалтай нийтлэгджээ. (Хүснэгт 2.)

### Хүснэгт 2 Мэдээллийн шууд эсэх цахим хуудас, сар тус бүрээр хувиар

	1-р сар		2-р сар		3-р сар		Нийт
	Шууд бус	Шууд	Шууд бус	Шууд	Шууд бус	Шууд	
<a href="http://www.amjilt.com">www.amjilt.com</a>					100		100%
<a href="http://www.factnews.mn">www.factnews.mn</a>	100						100%
<a href="http://www.gogo.mn">www.gogo.mn</a>	56		38			6	100%
<a href="http://www.medee.mn">www.medee.mn</a>	33	8	29		29		100%
<a href="http://www.news.mn">www.news.mn</a>	41	6	23	1	28	1	100%
<a href="http://www.olloo.mn">www.olloo.mn</a>	55		14	3	28		100%
<a href="http://www.shuud.mn">www.shuud.mn</a>	16	8	24		52		100%

Эмэгтэй улс төрчдийн талаарх өнгө аясын хувьд нийт мэдээллийн 80 хувь нь төвийг сахисан байдлаар, 12 хувь нь эерэг, 8 хувь нь сөрөг өнгө аястай. Өмнөх тайлантай харьцуулахад төвийг сахисан болон эерэг байдлаар мэдээлсэн хувь өсөж, сөрөг байдлаар бичсэн мэдээллийн хувь буурсан байв.

Төр засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй хүн байх эсэх тухайд [www.medee.mn](http://www.medee.mn), [www.olloo.mn](http://www.olloo.mn), [www.shuud.mn](http://www.shuud.mn) бүгд “*тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй*” гэж үзсэн. Харин [www.news.mn](http://www.news.mn) сайтын тухайд 53 хувь нь “*зайлиггүй хэрэгтэй*”, 29 хувь нь “*тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй*”, 18 хувь нь “*байсан ч болно байхгүй байсан ч болно*” гэж үзжээ. (Зураг 14.)

Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл байрласан булангуудыг өмнөх тайлантай харьцуулан харахад өмнө нь мэдээлэл гарч ирээгүй шинээр есөн булан нэмэгдсэн. Энэ есөн булан дах мэдээлэл нийт мэдээллийн 16 хувийг эзэлж байна. Хамгийн их мэдээлэл байрласан “Улс төр” булангийн мэдээлэл өмнөхөөс 63 хувиар нэмэгдэж, харин “Улс төрчид” булангийн мэдээлэл 92 хувиар буурсан байна. Үүнээс харахад 2012 оны эхний гурван сарын байдлаар эмэгтэй улс төрчдийн талаар өмнөх мониторингийн үеэс илүү өргөн хүрээнд мэдээлэл гаргасныг харуулж байна. (Зураг 15.)

### Цахим хуудсуудад бичигдсэн зарим эмэгтэй улс төрчдийн талаарх ойлголт, тодорхойлолт, төсөөлөл

- ❖ Хичээнгүй, дайчин чанараараа ялгарч байсан юм.
- ❖ Ухаалаг, ямар ч асуудалд тууштай хандаж чаддаг нь манай эмэгтэйчүүдийн давуу тал
- ❖ Эмэгтэйчүүд хэзээ ч үнэг хөөж онгоц унагадаггүй. Хувийн эрх ашгаа төрийн дээр тавьдаггүй, аливаад зарчим ч, нягт нямбай ханддаг.
- ❖ Улс төр гэдэг хатуу тоглоом тэр хэрээр эмэгтэйчүүд маань хатуужилтай болж, ямар ч асуудалд эрэгтэй хүнээс дутахгүй шийдвэр гаргадаг баймаар байна.
- ❖ Эмэгтэйчүүд улс төрд орж ирэх нь шийдлийг эрүүл саруул гаргахад нөлөөлдөг сайн талтай. Манай улс төрд эмэгтэйчүүдийн уян хатан мэдрэмж, аливаа асуудалд ухаалгаар хандаж чаддаг тэр чанар дутаад байна.
- ❖ Зүгээр л хов ярьж суудаг эмэгтэй хүний зангаар улс төрд хандаад байна
- ❖ Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд бол хүчирхэг болж чадахгүй байна. Энэ нь эмэгтэйчүүдийн олуулаа байж чаддаггүй нэг зантай холбоотой юм шиг байгаа юм.

## GOOGLE.MN ҮР ДҮН

Google хайлтын системээс “Эмэгтэй нэр дэвшигч”, “Эмэгтэй улс төрч” гэсэн хоёр түлхүүр үг ашиглан хайлт хийж, 2012 оны 1, 2, 3-р саруудын сонгосон өдрүүдэд гарсан мэдээллийг шүүн дүн шинжилгээ хийсэн. Энэ хайлтаар сонгосон 8 цахим хуудас дээрх мэдээлэл давхардан гарч ирвэл хасаж тооцсон. Нэгдүгээр сард 4, хоёрдугаар сард 6, гуравдугаар сард 11, нийт давхардсан байдлаар 21 цахим хуудаснаас мэдээлэл олдсон. (Хүснэгт 3.)

### Хүснэгт 3. Хайлтаар гар ирсэн мэдээллүүд хадгалагдаж байсан цахим хуудсууд

	1-р сарын 16-22-ны өдөр	2-р сарын 1-7-ны өдөр	3-р сарын 1-7-ны өдөр
1	<a href="http://www.mass.mn">www.mass.mn</a>	<a href="http://www.mass.mn">www.mass.mn</a>	<a href="http://www.mass.mn">www.mass.mn</a>
2	<a href="http://www.unen.mn">www.unen.mn</a>	<a href="http://www.yanaa.mn">www.yanaa.mn</a>	<a href="http://www.unen.mn">www.unen.mn</a>
3	<a href="http://www.mongolnews.mn">www.mongolnews.mn</a>	<a href="http://www.orloo.mn">www.orloo.mn</a>	<a href="http://www.zugeer.mn">www.zugeer.mn</a>
4	<a href="http://www.gonews.mn">www.gonews.mn</a>	<a href="http://www.wsp.mn">www.wsp.mn</a>	<a href="http://www.politics.chuhal.mn">www.politics.chuhal.mn</a>
5		<a href="http://www.times.mn">www.times.mn</a>	<a href="http://www.mobile.news.mn">www.mobile.news.mn</a>
6		<a href="http://www.news.myub.mn">www.news.myub.mn</a>	<a href="http://www.grandnews.mn">www.grandnews.mn</a>
7			<a href="http://www.chinggis-udgan.blogspot.com">www.chinggis-udgan.blogspot.com</a>
8			<a href="http://www.mminfo.mn">www.mminfo.mn</a>
9			<a href="http://www.sonin.mn">www.sonin.mn</a>
10			<a href="http://www.mongolianyouth.mn">www.mongolianyouth.mn</a>
11			<a href="http://www.ulstur.com">www.ulstur.com</a>

Өмнөх мониторингоор 48 цахим хуудаснаас 17 эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл гарч байсан бол энэ удаад 21 цахим хуудаснаас 44 эмэгтэй улс төрчид болж өслөө. Энэ нь удахгүй болох 2012 оны сонгуультай холбогдон улс төрийн нам, эвсэл, холбоодоос мөн хувиараа бие даан нэр дэвшигчид хэн, хэн байх вэ, хэн, хэн байж болох вэ гэсэн санал, таамаглалын шинжтэй мэдээлэл, түүнчлэн ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийн өдрийг угтсан үйл ажиллагаатай холбогдох мэдээллүүд нилээд гарсантай холбоотой юм.

Өмнөх мониторингоор Д.Оюунхорол, С.Оюун, Ц.Оюунгэрэл нартай холбоотой мэдээлэл хамгийн олон олдож, нийт мэдээллийн 31 хувийг эзэлж байсан. Харин энэ удаа Т.Ганди, Д.Оюунхорол, С.Оюун, Д.Арвин нар тэргүүлж, нийт мэдээллийн 25 хувийг эзэлж байна. Нэр заагаагүй ерөнхийдөө эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийн эзлэх хувь 26 хувиас 11 хувь болж буурсан байна. (Зураг 16.)

### Зураг 4 Хамгийн олон удаа мэдээлэл гарч ирсэн эмэгтэй улс төрчид (тоогоор)



Өмнөх мониторингоор Д.Оюунхорол (*Шилдэг эмэгтэй улс төрчөөр шалгарч байсан.*) нийт мэдээллийн 13 хувийг эзэлж, 6-н зурагтайгаар тэргүүлж байсан бол энэ удаа Т.Ганди (*Сайд нарын асуудлыг хэлэлцэж байсан үе*) 7,3 хувь, 6-н зурагтайгаар тэргүүлэв. (**Зураг 16.**) Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийн 16 хувь нь тухайн цахим хуудасны “Улс төр” гэсэн буланд, 2 хувь нь “Нийгэм” гэсэн буланд, 1 хувь нь “Эдийн засаг” гэсэн буланд, үлдсэн 81 хувь нь ямар буланд тавигдсан нь тодорхой бус байв. (**Зураг 17.**) Нийт мэдээллийн 96 хувь нь шууд бусаар 4 хувь нь шууд байдалтай гарсан.

Нийт мэдээллийн 56 хувь нь төвийг сахисан байдлаар, 39,5 хувь нь эерэг, 4 хувь нь сөрөг байдлаар бичигдсэн байна. Өмнөх мониторингийн дүнтэй харьцуулахад эерэг үнэлэмж 36 хувиар, төвийг сахисан байдал 135 хувиар өсөж, сөрөг үнэлэмж 20 хувиар буурсан байна. (**Зураг 18.**)

Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд байх эсэхийг хөндсөн 5 мэдээлэл гарснаас 4 нь төр засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй, 1 нь төр засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэй улс төрч байж ч болно байхгүй байсан ч болно, төдийлөн чухал биш гэж үзэж байна.

*Эмэгтэй улс төрчид, эмэгтэй нэр дэвшигчдийг үнэлж тодорхойлсон байдал*

- ❖ Эмэгтэйчүүдийг сонгохдоо нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн байдал, хэдэн хүнийг араасаа дагуулж байна, нийгмийн өнгө төрхийг илэрхийлэгч байж чадаж байна уу гэдгийг ялангуяа нийслэлд нэр дэвших хүмүүсээс харах ёстой гэж боддог
- ❖ Хэдий өөрөө нам дотроо амбицладаг ч яг УИХ-ын сонгуульд нэр дэвшээд суудал зулгаагаад ирэх эмэгтэйчүүд үнэндээ ховор юм. Нийт масс буюу олон нийтэд танигдаагүй гэдгээс эхлээд тэднээс намынхаа шалгуурыг давах эмэгтэйчүүд үнэндээ ховор.
- ❖ “Хэрэв эмэгтэйчүүд та нар тийм мундаг юм бол, бидэнтэй өрсөлдөөд гараад ирэх боломж байна, та нар чадахгүй л байна шүү дээ” гэдэг. Эмэгтэйчүүд тэдэн шиг хор найруулж, хуйвалдаж, луйвардаж төвддөггүй
- ❖ Монголчуудын хувьд амьдралын ачааны тэн хагасаас илүүг эмэгтэйчүүд нуруун дээрээ үүрч байна. Монголын эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр, гүйцэтгэх түвшний ажил мэргэжлийн туршлага их учраас тэдний мэдлэг, чадвар, ажлын туршлагыг улс төр болон нийгмийн зөв тогтолцоог хөгжүүлэхэд ашиглах цаг үе иржээ.
- ❖ Улс төрийн намуудын хувьд хамгийн гол нь нам сонгуульд ялах асуудал байдаг тул сонгуулийн зардлыг санхүүжүүлэх хөрөнгө мөнгө багатай эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх нь сонгуульд ялагдах магадлалтай. Иймээс сонгуульд нэг суудлаа алдах эрсдэл өндөр байдаг тул улс төрийн намууд эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлдэггүй.
- ❖ Эрчүүдтэй ана мана үзэлцэн өөрийн байр сууриа хамгаалж чаддаг
- ❖ Төрийн төмөр хатагтай
- ❖ Зөөлөн зөөлөн дуутай чанга хатуу сайд-бүсгүй
- ❖ Өнөөгийн улс төрч эмэгтэйчүүдэд бүгдэд нь хэнд ч хэлье гэсэнээ хэлчихдэг шударга зан чанар харагдаж байдаг.

## ТЕЛЕВИЗИЙН ҮР ДҮН

Төслийн хоёр дах шатны мониторингийн хамрах хүрээг өргөжүүлж, гурван телевизийн 7 хоногийн эфирийн нэвтрүүлгийг нэмж хамруулсан. Үүнд:

МҮОНРТ, Боловсрол суваг ТВ, 25-р суваг ТВ (I суваг) гэсэн гурван телевизийн 2012-оны 1-р сарын 16-22-ны өдрийг хүртэлх нийт 7 хоногийн нэвтрүүлэгт мониторинг хийлээ. МҮОНРТ-ийн өдрийн эфирийн цаг 15:43:3-ээс 16:25:7 секунд үргэлжилж, 7-н өдрийн эфирийн нийт цаг 112:36:33 секунд, “25-р суваг” ТВ-ийн өдрийн эфирийн цаг 16:26:10-ээс 18:25:28 секунд үргэлжилж, 7-н өдрийн эфирийн нийт цаг болох 122:11:34 секундын хугацаанд мониторинг хийсэн. Харин Боловсрол суваг ТВ “Мэдээг мэдээлэл болгоё” гэсэн уриатай ажилладаг. Цаг үеийн мэдээлэл гэж гардаггүй харин иргэдэд мэдлэг олгох зорилготой ажилладаг. Мониторингийн хугацаанд 1-р сарын 21-ны өдрийн “Би иргэн” нэвтрүүлгийг М.Батчимэг хөтлөн явуулсан нь тус телевизээр эмэгтэй улс төрч гарсан ганц тохиолдол байлаа.

Гурван телевизээр Б.Батзул, Г.Баасан, Г.Уянга, Д.Оюунхорол, Д.Туяа, Ж.Занаа, М.Батчимэг, М.Чимгээ, Н.Болормаа, Н.Удвал, Р.Бурмаа, С.Одонтуяа, С.Оюун, Т.Ганди, Ч.Сосормаа гэсэн 15 эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл, нийт 2 цаг 50 минут 53 секундын хугацаанд цацагдсан байна. МҮОНРТ-ээр Т.Ганди, Д.Оюунхорол, Ч.Сосормаа, С.Оюун, Н.Болормаа, Г.Уянга, Н.Удвал, Ж.Занаа гэсэн 8 эмэгтэй улс төрчдийн тухай нийт 11 минут 34 секунд гарсан. Хамгийн удаан гарсан хүний хугацаа 5 минут ч хүрэхгүй байна. (Т.Ганди 4 минут 30 секунд) *(Зураг 19, 20)*

25-р суваг ТВ-ээр Г.Уянга, Т.Ганди, Д.Оюунхорол, М.Чимгээ, Р.Бурмаа, Д.Туяа, С.Одонтуяа, Б.Батзул, Г.Баасан гэсэн 9 хүний тухай нийт хугацаа 1 цаг 39 минут 19 секунд үргэлжилсэн. Үүнээс 1 цаг 16 минут 24 секунд нь С.Одонтуяагийн оролцсон “Bon appetit” гэх нэвтрүүлэгт эзэлж, үлдсэн найман хүнтэй холбоотой мэдээлэл нийт 22 минут 55 секунд болж байна. *(Зураг 21, 22)* Үргэлжлэх хугацаа богино боловч бараг өдөр бүр телевизүүдээр (МҮОНРТ, 25-р суваг ТВ) эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл гарсан байна. *(Хүснэгт 4.)*

### Хүснэгт 4 Телевизийн мэдээлэл гарсан өдрүүд (хувиар)

	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням	Нийт хувь
	2012.01.16	2012.01.17	2012.01.18.	2012.01.19.	2012.01.20.	2012.01.21.	2012.01.22.	
<b>МҮОНРТ</b>	11.5	11.5	23	26.9	7.7		19.2	<b>100</b>
<b>25-р суваг ТВ</b>	19.6	11.7	13.7	31.3	11.7	3.9	7.8	<b>100</b>
<b>Боловсрол суваг</b>						100		<b>100</b>

МҮОНРТ-ээр гарсан нийт мэдээллийн 65 хувь нь шууд бусаар, 35 хувь нь шууд, 25-р суваг ТВ-ийн нийт мэдээллийн 59 хувь нь шууд бусаар, 41 хувь нь шууд байдлаар цацагджээ. *(Зураг 23, 24.)*

25-р суваг ТВ-ээр эмэгтэй улс төрчидтэй холбоотой нийт мэдээллийн 3,9 хувь нь эерэг, 82,3 хувь нь төвийг сахисан, 13,6 сөрөг байдлаар мэдээлсэн. Харин МҮОНРТ-ээр цацагдсан мэдээллийн 92,3 хувь нь төвийг сахисан байдлаар, үлдсэн 7,7 хувь нь эерэг байдлаар гарсан байна. *(Зураг 25.)*

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Их Британий Элчин Сайдын яамын санхүүжилтээр, Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч эмэгтэйчүүдийг дэмжих нь” төслийн хүрээнд Глоб Интернэшнл ТББ 2 үе шаттай хэвлэл мэдээллийн мониторинг хийж гүйцэтгэлээ.

Нэгдүгээр үе шатанд 2008 оны УИХ-ын сонгууль (2008 оны 6-р сарын 21-27-ны өдөр), Ерөнхийлөгчийн “Иргэний танхим”-д болсон УИХ-ын сонгуулийн тухай хууль-Жендерийн тэгш эрх сэдэвт хэлэлцүүлэг (2011 оны 6-р сарын 13-19-ны өдөр), сонгуулийн хууль, эмэгтэйчүүдийн квотын асуудлыг эцэслэн шийдвэрлэх 2011 оны Намрын чуулган (2011 оны 10-р сарын 12-25-ны өдрийг дуустал)-тай холбогдуулан 3-н хэсэг хугацааг сонгон авч 5 сонин, 8 цахим хуудас, google.mn хайлтын системийн мэдээллийг хамруулсан.

Хоёрдугаар үе шатанд 2012 оны 1-р сарын 16-22-ны өдөр, 2, 3-р сарын 1-7-ны өдрийг дуустал 5 сонин, 8 цахим хуудас, google.mn хайлтын систем, нэмж 3 телевизийн 7 хоногийн эфирийн нэвтрүүлэгт мониторинг хийж, үр дүнг гаргалаа.

Хоёр мониторингийн мэдээлэл цуглуулсан арга зүй адилхан. Харин 2-р шатанд шинээр 3 телевиз орж ирсэнтэй холбогдуулан телевизийн нэвтрүүлэгт зориулсан түлхүүр асуулт бүхий тэмдэглэлт хүснэгт нэмэгдэж, сонин дээрх мэдээлэл төлбөртэй, төлбөргүйг тодруулсан асуултыг 2-р шатанд хассан болно.

Мониторингийн хугацаанд эмэгтэй улс төрчтэй холбоотой 420 мэдээлэл гарсан байна. Үүнээс 15 хувь нь сонинд нийтлэгдсэн, 66 хувь нь интернэтэд (8 цахим хуудас, google.mn) тавигдсан, 19 хувь нь телевизээр цацагдсан байна.

Өмнөх тайлантай харьцуулахад нийт эмэгтэйчүүдийн тоо 10 хүнээр нэмэгдэж, 52 эмэгтэй улс төрчдийн тухай мэдээлэл гарсан. Мэдээлэл гарсан тоогоороо 1-р шатанд С.Оюун, 2-р шатанд Д.Оюунхорол тэргүүллээ. Одоогийн УИХ-ын эмэгтэй гишүүд болох С.Оюун, Д.Арвин, Д.Оюунхорол нартай холбоотой мэдээллийн нийт мэдээлэлд эзлэх хувь 39-29 хувь болж буурсан ч нь 2-р шатанд сониноос бусад ХМХ-үүдэд дахин тэргүүлж байгаа нь эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл одоогийн УИХ-ын 3 эмэгтэй гишүүн дээр төвлөрч байна.

### **Эмэгтэй улс төрчийн талаарх мэдээлэл хангалтгүй байна.**

Эмэгтэй улс төрчдийн талаар сонинд эрэгтэйчүүдээс 5 дахин бага давтажтай мэдээлж, 9 дахин бага талбайд бичжээ. Мэдээлэл гарсан тоогоор С.Одонтуяа, П.Батчимэг нар тэргүүлж байгаа боловч мэдээллийн талбайн хэмжээ сонины тал нүүр болж байна. Харин М.Ичинноров, Н.Удвал нартай холбоотой тус бүр 2 мэдээлэл гарсан ч мэдээлэл гарсан талбайн хэмжээ 3,8 сонины нүүр материал гарчээ. Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийн 50 хувь нь 1-4-р нүүрэнд нийтлэгдсэн байна.

Цахим хуудасны хувьд эмэгтэй улс төрчдийн тоо 27-22 болж буурсан. Мэдээлэл гарсан тоогоороо Д.Оюунхорол, Д.Арвин, Т.Ганди, С.Оюун нар, мэдээлэл байршуулсан тоогоороо [www.news.mn](http://www.news.mn) дахин тэргүүллээ. Өмнөх мониторингийн дүнтэй харьцуулахад хамгийн их мэдээлэл байрласан “Улс төр” булангийн мэдээлэл 63 хувиар, нэмэгдэж, “Улс төрчид” булангийн мэдээлэл 92 хувиар буурсан байна.

Google хайлтын системийн хувьд мэдээлэл байрласан цахим хуудасны тоо буурч, мэдээлэл гарсан хүний тоо өсөж, давхардсан байдлаар 21 сайтаас 44 эмэгтэй улс төрчдийн тухай мэдээлэл илэрсэн. Өмнөх мониторингийн үеэр Д.Оюунхорол “Шилдэг эмэгтэй улс төрч”-өөр шалгарч хамгийн их мэдээлэл гарсан эмэгтэй улс төрч болж байсан бол 2-р шатанд сайд нарыг дахин томилохтой холбогдож Т.Гандитай холбоотой мэдээлэл их гарч байлаа.

Гурван телевизээр 15 эмэгтэй улс төрчдийн тухай нийт 2 цаг 50 минут, 53 секундын хугацаанд гаргасан байна. Үүнээс мониторинг хийгдсэн 7 хоногийн хугацаанд нэг нэг удаа гарч, бүтэн нэвтрүүлэгт оролцсон С.Одонтуяа, М.Батчимэг нар нийлээд 2 цаг 16 минут 24 секунд үргэлжилсэн. Үлдсэн 13 хүний тухай нийт 34 минут 29 секунд мэдээлэл гарсан байна. Энэ нь нэг хүнд 3 хүрэхгүй минут оногдож байна. Мэдээллийн 73 хувь нь аль нэг мэдээний цагаар гарсан ба 1-р сарын 19-нд буюу Пүрэв гаригт хамгийн олон хүний тухай мэдээлэл цацагджээ.

**Тухайн нэр дэвшигчийн болон төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэйчүүдийн талаарх үнэлэмж эерэг хандлагатай болжээ.**

Өмнөх тайлан дээр эмэгтэйчүүдтэй холбоотой мэдээллийн 58 хувь нь төвийг сахисан байдлаар, 25 хувь эерэг байдлаар, 17 хувь сөрөг байдлаар бичигдсэн байсан. Харин 2-р шатанд нийт мэдээллийн 77 хувь нь төвийг сахисан, 16 хувь нь эерэг, 6 хувь сөрөг байдлаар нийтлэгдсэн. Сонгогдсон ХМХ-үүдийн хувьд эерэг мэдээлэл давамгайлсан байна.

Сонин дээр гарсан эмэгтэйчүүдийн тухай мэдээллийн 91 хувь нь төвийг сахисан, 6 хувь нь эерэг, 3 хувь нь сөрөг байдлаар бичигдсэн.

Цахим хуудсуудын хувьд нэр бүхий эмэгтэйчүүдийн тухай мэдээллийн 80,5 хувь нь төвийг сахисан байдлаар, 12 хувь нь эерэг, 7,5 хувь нь сөрөг байдлаар бичсэн. Төр, засгийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд байх эсэх, хэр чухал байгаа талаар дурьдагдсан мэдээллүүдийн 37 хувь нь “*зайлишгүй хэрэгтэй*”, 50 хувь нь “*тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй*”, 13 хувь нь “*байж ч болно байхгүй байсан ч болно*” гэж үзсэн.

Google хайлтын системийн хувд 56 хувь нь төвийг сахисан байдлаар, 39,5 хувь нь эерэг, 4 хувь нь сөрөг байдлаар бичигдсэн. Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд байх эсэхийг хөндсөн таван мэдээлэл гарснаас 4 нь тодорхой хэмжээгээр байх хэрэгтэй, 1 нь эмэгтэй улс төрч байж ч болно байхгүй байсан ч болно, төдийлөн чухал биш гэж үзсэн байна.

25-р суваг ТВ-ээр гарсан эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийн 4 хувь нь эерэг, 82 хувь нь төвийг сахисан байдлаар, 4 хувь нь сөрөг байдлаар гарсан. Харин МҮОНРТ-ээр гарсан мэдээллийн 92 хувь нь төвийг сахисан байдлаар, үлдсэн 8 хувь нь эерэг өнгө аястай байв.

**Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл шууд бус байдлаар бичигдэж байна.**

ХМХ-үүдээр гарч байгаа эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийг шууд болон шууд бус гэж ангилсан. Нэр нь гарч байгаа эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээллийг тухайн хүн өөрөө өгсөн бол шууд, өөр эх сурвалжаас буюу хэн нэгэн улс төрч, иргэд, эсвэл сэтгүүлч хэлсэн, бичсэн мэдээллийг шууд бус хэмээн үзсэн. Шууд эх сурвалжтай мэдээлэл сонин дээр нэлээд бага (5 дахин), интернэт дээр эрс бага (13-24 дахин), телевиз дээр харьцангуй бага (1-2 дахин бага) хувиар гарсан байна.

**Эмэгтэй улс төрчдийн талаарх ойлголт, үнэлэмж, тодорхойлолт, төсөөлөлд эерэг хандлагатай болжээ.**

Хоёр мониторингийн явцад давхардаж байгаа хэсгийг доорх харьцуулсан хүснэгтүүдээс харж болно.

Төр засгийн шийдвэр гаргах түвшинд ажиллах эмэгтэй ямар байх ёстой вэ?

- Шударга, авлига хээл хахуулд автдаггүй

<b>1-р шатын тайлан</b>	<b>2-р шатны тайлан</b>
Улс төрийг шударгаар явуулах, авлигагүй төрийн үйлчилгээг эмэгтэй улс төрч бүрдүүлнэ. Нийгмийн шударга ёсыг тогтоох. Эмэгтэй улс төрч хэзээ ч үзэл бодлоо мөнгөөр худалддаггүй шударга байж чаддаг. ... багийн тоглолт гэдэг хуйвалдаанд оролцохгүй	Хор найруулж, хуйвалдаж, луйвардаж төвддөггүй. Эмэгтэйчүүд улс төрд орж ирэх нь шийдлийг эрүүл саруул гаргахад нөлөөлдөг сайн талтай. Хувийн эрх ашгаа төрийн дээр тавьдаггүй,

- Нарийн мэдрэмжтэй, зөөлөн сэтгэлтэй, халамжтай, асуудалд намбай ханддаг

<b>1-р шатын тайлан</b>	<b>2-р шатны тайлан</b>
Монгол Улсын улс төрд эмэгтэйчүүдийн зөөлөн сэтгэл, хайр халамж дутаж байна. ... нийгмийн халамж, эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, эрүүл мэндийн үйлчилгээ, эмзэг бүлгийнхэнд туслах асуудлуудыг гярхай харах талаасаа эмэгтэйчүүд илүү.	Манай улс төрд эмэгтэйчүүдийн уян хатан мэдрэмж, аливаа асуудалд ухаалгаар хандаж чаддаг тэр чанар дутаад байна. Аливаад зарчим ч, нягт нямбай ханддаг. Улс төрд эмэгтэй хүн олон байвал их сайн. Учир нь эмэгтэй хүн бусадтай их хүндэтгэлтэй харьцдаг, ажил үйлс, өгсөн даалгаварт нямбай цэгцтэй ханддаг.

- Сэтгэлийн хаттай байх

<b>1-р шатын тайлан</b>	<b>2-р шатны тайлан</b>
Улс төрийн нөхцөл байдал ч өөрчлөгддөг гэдгийг тооцоолох хаттай байх учиртай эмэгтэйчүүд.	Улс төр гэдэг хатуу тоглоом тэр хэрээр эмэгтэйчүүд маань хатуужилтай болж, ямар ч асуудалд эрэгтэй хүнээс дутахгүй шийдвэр гаргадаг баймаар байна.

- Сайн боловсорч танигдах хэрэгтэй

<b>1-р шатын тайлан</b>	<b>2-р шатны тайлан</b>
Мөн эмэгтэйчүүдийн хувьд боловсрох шаардлага байгааг энэ үеэр онцоллоо.	Хэдий өөрөө нам дотроо амбицладаг ч яг УИХ-ын сонгуульд нэр дэвшээд суудал зулгаагаад ирэх эмэгтэйчүүд үнэндээ ховор юм. Нийт масс буюу олон нийтэд танигдаагүй гэдгээс эхлээд тэднээс намынхаа шалгуурыг давах эмэгтэйчүүд үнэндээ ховор.

- Мөнгө, санхүүгийн боломжтой байх хэрэгтэй

1-р шатын тайлан	2-р шатны тайлан
Тавин сая, зуун сая төгрөгийг өөрийн хөрөнгөөс гаргаж өгөх эмэгтэй улс төрч тун ховор.	Хөрөнгө мөнгө багатай эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэх нь сонгуульд ялагдах магадлалтай.

Төр засгийн шийдвэр гаргах түвшинд яагаад эмэгтэйчүүд тохирохгүй вэ?

- Эмэгтэйчүүд - Эвсэж чаддаггүй, эмэгтэйчүүдээ дэмждэггүй

1-р шатын тайлан	2-р шатны тайлан
Гэхдээ эмэгтэйчүүд үнэхээр эвсэж чаддаггүй юм байна гэдгийг олон зүйл дээрээс харж байлаа. ... Эмэгтэйчүүд маань эмэгтэйчүүдээ дэмжихгүй	Эмэгтэйчүүд эдийн засгийн хувьд бол хүчирхэг болж чадахгүй байна. Энэ нь эмэгтэйчүүдийн олуулаа байж чаддаггүй нэг зантай холбоотой юм шиг байгаа юм.

Мониторингийн явцад эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэлд өмнө нь нэлээд гарч байсан эмэгтэйчүүд 2-рт, хүүхэд, гэр бүлийн хүрээний хүн, эрчүүдийн туслах гэсэн тэгш бус хандлагыг агуулсан мэдээлэл 2-р шатны мониторингийн явцад гарч ирсэнгүй. Мөн чанарын нэг том өөрчлөлт гарсан нь 1-р шатны мониторингийн явцад эмэгтэй улс төрчдийг доромжилсон, сөрөг утга, агуулгатай мэдээлэл нэлээд гарсан байсан. Харин 2-р шатны мониторингийн явцад **“Зүгээр л хов ярьж суудаг эмэгтэй хүний зангаар улс төрд хандаад байна”** гэсэн доромж үгийг эс тооцвол бусад нь эерэг агуулгатай байсан юм.


1-р шатны тайлан - Сөрөг	2-р шатны тайлан - Эерэг
... “Эмшсэн эртэй гэр-улсад ёс суртахууны уламжлал хийгээд хуулийн заалт тэр бүр хэрэгждэггүй” "Улс төрийн биеэ үнэлэгч", "банзал авгай" гэдэг нэр гуншин зүүж өгдөг. Урьд нь сонгогдсон цөөн эмэгтэйчүүд хувийн гэхээсээ илүүтэй улс төрийн аль нэг нам хүчний рейтингийн фонноор л гарч ирж байгаа билээ.	Ухаалаг, ямар ч асуудалд тууштай хандаж чаддаг нь манай эмэгтэйчүүдийн давуу тал Монголын эмэгтэйчүүдийн боловсролын түвшин өндөр, гүйцэтгэх түвшний ажил мэргэжлийн туршлага их учраас тэдний мэдлэг, чадвар, ажлын туршлагыг улс төр болон нийгмийн зөв тогтолцоог хөгжүүлэхэд ашиглах цаг үе иржээ. Өнөөгийн улс төрч эмэгтэйчүүдэд бүгдэд нь хэнд ч хэлье гэсэнээ хэлчихдэг шударга зан чанар харагдаж байдаг. Эрчүүдтэй ана мана үзэлцэн өөрийн байр сууриа хамгаалж чаддаг

СОНИН


Зураг 5 Улс төрчидтэй холбоотой мэдээлэл




Зураг 6 Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл сонин тус бүрээр




Зураг 7 Эмэгтэй улс төрчидтэй холбоотой мэдээлэл ба сонины нүүр (хувиар)



**Зураг 8 Эмэгтэй улс төрчдийн талаарх өнгө аясыг сонин бүрээр авч үзвэл**




**Зураг 9 Мэдээллэл шууд, шууд бус байдлаар бичигдсэнийг сонин тус бүрээр харвал**



## ЦАХИМ ХУУДАС

Зураг 10 Цахим хуудас тус бүр дээр гарсан мэдээлэл ба хугацаа (хувиар)




Зураг 11 Цахим хуудсанд гарсан мэдээллийн тоо



**Зураг 12 Цахим хуудсанд гарсан фото зургийн тоо**




**Зураг 13 Мэдээллийн шууд эсэх цахим хуудас тус бүрээр хувиар**



**Зураг 14. Төр засгийн шийдвэр гаргах төвшинд эмэгтэйчүүд байх эсэх www.news.mn**




Зураг 15 Мэдээлэл гарсан булангууд (өмнөх тайлантай харьцуулсан байдлаар)




Зураг 16 Фото зургийн тоо



Зураг 17 Мэдээлэл гарсан булан хувиар



Зураг 18 Эмэгтэй улс төрчдийн талаарх өнгө аяс сар тус бүрээр (хувиар)




## ТЕЛЕВИЗ


Зураг 19 Холбогдох мэдээлэл (хувиар)




Зураг 20 Мэдээллийн үргэлжилсэн хугацаа




Зураг 21 Холбогдох мэдээлэл (хувиар)




Зураг 22 Мэдээллийн үргэлжлэх хугацаа



Зураг 23. Шууд эсэх



Зураг 24. Шууд эсэх



Зураг 25 Эмэгтэй улс төрчдийн талаарх өнгө аяс

